



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/92

Халбан

Иргэдэд газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эзэмшиж байгаа газраа өмчлөх хүсэлт гаргасан Шагдар ургийн овогтой Лхагваан Даваасүрэн (рс78062431)-д 6732000745 нэгж талбарын дугаартай 176,400 (нэг зуун далан зургаан мянга дөрвөн зуу) төгрөгийн үнэ бүхий Халбан багийн Мод толгой 5-513 тоот хаягт орших 840м² газрыг гэр орон сууц хашааны зориулалтаар өмчлүүлсүгэй.

2.Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газраа өмчилж авахаар шийдвэр гаргуулсан иргэний газрыг Улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулахыг Улсын бүртгэгч (Д.Дэлгэрмөрөн)- д даалгасугай.

3.Өмчилсөн газрыг мэдээллийн санд бүртгэн хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, захиргааны актыг өмчлөгчид мэдэгдэхийг Газрын даамал (Н.Цасанчихэр)-т үүрэг болгосугай.

4.Газар өмчлөгчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д, Байгаль орчны Улсын байцаагч (Д.Отгонжаргал) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА  Н.АНХБАЯР

